

**“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2020.04.22

№ ХТ-20/01

Улаанбаатар хот

Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

Цаг: 10:00-12:00

Хурал болсон газар: Цахимаар /live.mongolpost.mn/

Хурлын дарга: Д.Нарангэрэл /ТУЗ-ийн дарга/

Хурлын нарын бичгийн дарга: Д.Цэцгээ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 17

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: 96,602,023

Хурлын ирц: 97.0%

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
2. Компанийн 2018 оны ногдол ашиг тараасан тухай тайлан болон 2019 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсөв батлах тухай;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай;

“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 10:00 цагт компанийн 306 хурлын танхимд цахим хэлбэрээр явагдлаа. Цахим хуралд хурлын дарга Д.Нарангэрэл, Аудитын хорооны дарга Б.Балдорж, хараат бус гишүүн Б.Амарсанаа, Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар нар оролцлоо. ТУЗ-ийн бусад гишүүд болон компанийн удирдлагын багийн гишүүд цахимаар хуралд оролцлоо.

Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 2020 оны 04 сарын 13-ны өдрийн 09:00 цагаас 21-ний өдрийн 16:00 цаг хүртэл цахимаар бүртгэж, 2020 оны 04 сарын 22-ны өдрийн 10:00 цагт бүртгэлийн дүн буюу ирцийн дүнг нэгтгэн гаргаж, комиссын дарга О.Сарангэрэл нийт саналын эрхтэй хувьцааны 97.0 хувийг эзэмшигчид хуралд оролцож, хурлыг хүчин төгөлдөрт тооцсон тухай ирцийн мэдээлэл болон Тооллогын комиссын тогтоолыг танилцууллаа.

Хурлын дарга Д.Нарангэрэл хурлыг нээн, хурлын дэгийг танилцуулснаар цахим хурал 10:00 цагт эхэллээ.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ – 1: Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

- “Монгол шуудан” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар цахим хурал оролцож байгаа хувьцаа эзэмшигчдэд мэндчилгээ дэвшүүлж, компанийн 2019 оны тайлан танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав/

- Аудитын хорооны дарга Д.Балдорж компанийн 2019 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Аудитын хорооны дүгнэлтийг танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав/

- ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны тайлан, дүгнэлтийг танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав/

- Аудитын хорооны дарга Д.Балдорж компанийн 2018 оны ногдол ашиг тараасан тухай тайлан, 2019 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцууллаа.

Хувьцаа эзэмшигчдээс live.mongolpost.mn цахим хурлын чат-аар санал асуулга ирээгүй тул 2 дахь хэлэлцэх асуудлыг танилцууллаа.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ – 2: ТУЗ-ийн 2020 оны зардлын төсөв батлах тухай;

- Хараат бус гишүүн Б.Амарсанаа Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг танилцууллаа.

Хувьцаа эзэмшигчдээс live.mongolpost.mn цахим хурлын чат-аар санал асуулга ирээгүй тул 3 дахь хэлэлцэх асуудлыг танилцууллаа.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ – 2: ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;

- Хараат бус гишүүн Б.Амарсанаа ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулгыг хийв.

Хувьцаа эзэмшигчдээс live.mongolpost.mn цахим хурлын чат-аар санал асуулга ирээгүй тул санал хураалт авах, санал хураалтыг нэгтгэх 15 минутын завсарлага авлаа.

Өөр санал хүсэлт байхгүй гэснээр дээрх хэлэлцсэн асуудлуудын санал хураалтын ажиллагаанд орлоо. Санал хураалтын дүнг нэгтгэж дууссан тул хурлыг 11:30 цагт үргэлжлүүллээ. Тооллогын комиссын дарга О.Сарангэрэл, гишүүн Ч.Хандаа нар санал хураалтын дүн болон Тооллогын комиссын тогтоолыг танилцууллаа.

Хурлын дэгийн дагуу хурлын дарга Д.Нарангэрэл “Монгол шуудан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолыг уншиж танилцууллаа.

Хурлын дарга Д.Нарангэрэл: Цахим хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид болон компанийн удирдлагын багийн гишүүдэд баярласан талархсанаа илэрхийлье. Та бүхэнд аз жаргал сайн сайхан бүхнийг хүсье.

Энэ удаагийн хурал 11:35 цагт өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Д.НАРАНГЭРЭЛ

Д.ЦЭЦГЭЭ